



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/53

Шивээговь сум

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, “Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр III”-ийн 5.1.1, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоол, сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/42 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

- 1. Үндэсний бичиг, соёлын өдрийг тохиолдуулан “Эх хэл-Эрдмийн түлхүүр” монгол бичгийн олимпиадыг сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд, бага ангийн сурагчид болон төрийн албан хаагчид, иргэдийн дунд зохион байгуулсугай.
- 2. Монгол бичгийн олимпиадын удирдамжийг 1 дүгээр, арга хэмжээний зардалд зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1,880,000 (нэг сая найман зуун наян мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д даалгасугай.
- 4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 04...-р сарын 17...-ны өдрийн 1133 дугаар захирамжийн 1...-р хавсралт



**ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН
БАГА, ДУНД, АХЛАХ АНГИЙН СУРАЛЦАГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ЭХ ХЭЛ – ЭРДМИЙН ТҮЛХҮҮР 2024” ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**

ЗОРИЛГО: Суралцагчдын кирилл болон үндэсний бичгээр түргэн унших, алдаагүй зөв бичих сонирхол хэрэгцээнд тулгуурлаж, үндэсний бичгийн хичээлийн түргэн унших, зөв бичих чадварыг нэмэгдүүлэх

ХАМРАХ ХҮРЭЭ: Бага, дунд, ахлах ангийн бүх суралцагч

АНГИЛАЛ:

- Бага анги I-III анги
IV-V анги
- Дунд анги VI-VIII анги
- Ахлах анги IX-XI анги

ХУГАЦАА:

- Бага анги 3 үе шаттай, 04 сарын 15 - 05 сарын 03-ны өдөр хүртэл
- Дунд, ахлах анги 2 үе шаттай, 04 сарын 15 - 04 сарын 26-ны өдөр хүртэл

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

БАГА АНГИ: Кирилл бичгийн унших ба бичих, хэлзүйн чадваруудыг шалган шалгаруулна.

ДУНД, АХЛАХ АНГИ: Дараах чадваруудын дагуу сурах бичгийн хүрээнд шалган шалгаруулна.

📌 Унших чадвар

Үндэсний бичгээс кирилл бичиг рүү хөрвүүлэн бичих

📌 Бичих чадвар

Галиг болон кирилл бичгээс үндэсний бичиг рүү хөрвүүлэх

📌 Хэлзүй

1. Нэр үгийн хувилал
2. Үйл үгийн хувилал
3. Холбох эгшгийн дүрэм
4. Дүрс ялган бичих үгс
5. Өвөрмөц бичлэгтэй үгс

- ✓ Дүн үнэлгээг үе шат бүрд гүйцэтгэлийн хувиар гаргана.
- ✓ Хоёр шатны даалгаврын гүйцэтгэлийн дунджаар ангиудыг байр эзлүүлнэ.

ШАГНАЛ:

- ✓ Ангиудыг ангилал тус бүрт 1-3-р байр эзлүүлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулна.

**ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН
ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ЭХ ХЭЛ – ЭРДМИЙН ТҮЛХҮҮР 2024” ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**

Зорилго: Бүх нийтийн үндэсний бичгээрээ түргэн унших, алдаагүй зөв бичих сонирхол хэрэгцээнд тулгуурлаж, үндэсний бичгийн түргэн унших, зөв бичих чадварыг нэмэгдүүлэх

Хамрах хүрээ: Шивээговь сумын төрийн албаны байгууллага болон албан хаагчид
/Байгууллага бүрийн нийт ажилтан, албан хаагчид/

Хугацаа: 4 сарын 23-нд 13 цагаас

Хаана: Шивээговь сумын ЕБС, “Эх хэлний танхим”-д

- Илчлэг шивээ ОНӨҮГ- 3 албан хаагч
- ЗДТГ- 5 албан хаагч
- Иргэдийн хурал- 3 албан хаагч
- ШГС ЭМТ- 5 албан хаагч
- 3 дугаар цэцэрлэг- 5 албан хаагч
- ШГС ЕБС – 10 албан хаагч оролцоно.

Зохион байгуулалт:

“Үндэсний хөтөлбөр-3” хэрэгжүүлэх ажлын хүрээнд унших чадвар, бичих чадвар, хэлзүйн агуулгаар материал боловсруулж, олимпиад зохион байгуулна.

Шагнал:

Төрийн албан хаагчдаас эхний 3 байр эзлүүлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

**ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН
ИРГЭДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ЭХ ХЭЛ – ЭРДМИЙН ТҮЛХҮҮР 2024 ” ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**

Зорилго: Бүх нийтийн үндэсний бичгээрээ түргэн унших, алдаагүй зөв бичих сонирхол хэрэгцээнд тулгуурлаж, үндэсний бичгийн түргэн унших, зөв бичих чадварыг нэмэгдүүлэх

Хамрах хүрээ: Шивээговь сумын иргэд

Хугацаа: 4 сарын 24-нд 15 цагт

Хаана: Шивээговь сумын ЕБС, “Эх хэлний танхим”-д

Зохион байгуулалт:

“Үндэсний хөтөлбөр-3” хэрэгжүүлэх ажлын хүрээнд унших чадвар, бичих чадвар, хэлзүйн агуулгаар материал боловсруулж, олимпиад зохион байгуулна.

Шагнал:

Эхний 3 байр эзлүүлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Сумын Засаг даргын
2024 оны 04-р сарын 17-ны өдрийн
11.53 дугаар захирамжийн 2-р хавсралт



**ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ
“ЭХ ХЭЛ – ЭРДМИЙН ТҮЛХҮҮР 2024” ОЛИМПИАДЫН ТӨСӨВ**

2024.4.11

№	Нэр	Зориулалт	Тоо (ширхэг)	Ширхэгийн мөнгөн дүн	Нийт
ЕБС-ийн бага, дунд ахлах анги, багш нар					
1	I байр мөнгөн шагнал	Бага, дунд, ахлах анги	4	120000	480000
2	II байр мөнгөн шагнал	Бага, дунд, ахлах анги	4	100000	400000
3	III байр мөнгөн шагнал	Бага, дунд, ахлах анги	4	80000	320000
Төрийн албан хаагчид					
6	Мөнгөн шагнал	ТАХ	1	80000	80000
			1	70000	70000
			1	60000	60000
Иргэд					
7	Мөнгөн шагнал	Иргэд	1	80000	80000
			1	70000	70000
			1	60000	60000
Бичиг хэргийн зардал					
10	Бичгийн цаас	Олимпиад материал	3	20000	60000
11	Өргөмжлөлийн цаас	Бүгд	1	20000	20000
12	Жааз А4	Бүгд	15	12000	180000
Нийт					1880000

Төсөв гаргасан:
НБМЭРГЭЖИЛТЭН:

Б.АЛТАНСҮХ